

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Мах Импэкс” ХК -ийн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 4-р хороонд хэрэгжүүлэх “Мах боловсруулах үйлдвэр” төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А618 тоот тушаал, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, 2012 оны 5 сарын 17-ны өдрийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЗАСГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ 02 САРЫН 08-НЫ ӨДРИЙН 58 ДУГААР ТОГТООЛЫН 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэгт тусгасны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Мах Импэкс” ХК заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан болно.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

Төслийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулах бүрд төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгэж байх шаардлагатай. Мөн энэхүү БОХТ-ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрт нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

БОХТ-ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, үзлэгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдэд үндэслэн хийх, БОХТ-ний биелэлтийг дүгнэхдээ жилийн хяналт, үзлэгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг мөн авч үзэх ёстой.

БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 12 сарын 1-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Хүснэгт 1. Нэгдсэн дүн

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	2026 он	2027 он	2028 он	2029 он	2030 он
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1500.0	7500.0	4161.0	4242.0	3323.0
2.	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1500.0	1530.0	1612.3	1795.1	1977.7
3.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	--*--	--*--	--*--	--*--	--*--
4.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1300.0	1404.0	1509.0	1614.0	1719.0
5.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	6200.0	1296.0	1393.2	1491.7	1589.5
6.	Удирдлага зохион байгуулалт	Дотоод төсөв	Дотоод төсөв	Дотоод төсөв	Дотоод төсөв	Дотоод төсөв
7.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1400.0	1512.0	1625.4	1739.4	1851.04
Нийт: 74035.34		12500.0	13142.0	10300.0	10882.2	10460.24

1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Мах-Импекс” ХК-ийн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 4-р хорооны нутагт хэрэгжүүлэх “Мах боловсруулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Агаар орчны бохирдол	Агаарын тоосны (TSP, PM10, PM2.5) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	Агаар орчин	удаа	1	Үйл ажилгааны дотоод зардалаар тусган хэрэгжүүлэх		Жилд 1 удаа	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016
		Агаарын бохирдлын (NO2, SO2, CO, Тоос) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	Агаар орчин	удаа	1	Үйл ажилгааны дотоод зардалаар тусган хэрэгжүүлэх		Жилд 1 удаа	
Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрээс ялгарах хийн хаягдлын хэмжээнд хяналт тавих, тос маслыг тогтоосон мот/цаг тутамд сольж байх		Агаар орчин	Тогтмол			Үйл ажилгааны дотоод зардалаар тусган хэрэгжүүлэх		Тухай бүр	
Тээврийн хэрэгслүүдийн янданд утааны шүүлтүүр тавих /TWCAT002, TWCAT0061 маркийн шүүлтүүр/		Агаар орчин	удаа	1	Үйл ажилгааны дотоод зардалаар тусган хэрэгжүүлэх		Жилд 1 удаа		
4	Хөдөлмөрийн орчны байрны үнэлгээ хийлгэх	Агаар орчин	удаа	1	Үйл ажиллагааны зардал		2026-2030		
2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
5	Усан орчин бохирдох, Үйлдвэрлэл болон ажилчдын	Ажлын байрандариутгал халдваргүйтгэл хийх зөвлөмж	Эрүүл ахуй	удаа	Тогтмаол	Үйл ажиллагааны зардал		Сард 1 удаа	“Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль NS 6561:2015
6		Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл гаргуулах	Технологийн хаягдал бохир ус	Иж бүрэн	1	Үйл ажиллагааны зардал		Жилд 1 удаа	

7	ахуй хэрэглээнд ашиглах усны хэмжээгээр газрын доорх усны нөөц буурах	Хаягдал ус цэвэрлэх УЦБ ашиглалтад оруулах	Технологийн хаягдал бохир ус	Иж бүрэн	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардал	Жилд 1 удаа	MNS 4943:2015 MNS 6734:2018
8		Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Ус хэмнэх	ширхэг	Тогтмол	Үйл ажиллагааны зардал	Сард 1 удаа	“Усны тухай хууль”
9		Ус хэмнэх төлөвлөгөө гаргаж мөрдөн ажиллах	Иж бүрэн	удаа	4	Үйл ажиллагааны зардал	Улиралд дутам	
10		Усны газраас ус ашиглуулах дүгнэлт, гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	Ус ашиглалт	удаа	Үйл ажиллагааны зардал		Жилд 1 удаа	Усны тухай хууль Ус Бохирдуулсны төлбөрийн тухай хууль
3. Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ								
11	Хөрсний бохирдол	Зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх	Төслийн талбай	удаа	Үйл ажиллагааны зардал		Сард 1 удаа	MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 3297:1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин
12		Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх	Төслийн талбай	удаа	Үйл ажиллагааны зардал		Жилд 1 удаа	
13		Асгаралтын иж бүрдэл нэмж байршуулах	Төслийн талбайн хөрс	тогтмол	2500		Жилд 1 удаа	
14		хог хаягдлын цуглуулах хэсэг, орц гарц, агуулахын гадаа, зогсоол гэх мэт газрын бетондсон талбайг сэргээн засварлах	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		Жилд 1 удаа	газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ”
Дүн						2500.0		
4. Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ								
15	Ургамал	Төслийн хашаан доторх сул чөлөөт талбайг тарималжуулж нөхөн сэргээх зөвлөмж	Төслийн талбай	удаа	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд зардал тусгагдсан		Жилд 1 удаа	Нөхөн сэргээлтийн аргачлал Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай MNS 4585:2016
Нийт дүн						2,500.0		

1.2 Орчны цэцэрлэгжүүлэлт, нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйлд “Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх” гэж заасны дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байна. Орчны цэцэрлэгжүүлэлт, нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд төслийн талбайд жилд 20 ширхэг мод тарина.

Хүснэгт 3. Орчны тохижилт, сэргээлтийн төлөвлөгөө

№	Тарих модны төрөл	Тариалах газар	Ач холбогдол	Жилд тарих тоо хэмжээ, ш	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Авах боломжтой газар
1	Улиас	Төслийн талбайд	Улиас нь бургасны овогт хамаарна, фитонид хэмээх агаарыг цэвэршүүлэх бодисыг их агуулдаг тул хот сууринд тарьж ургуулахад тохиромжтой.	10ш	4 нас /1.5м/ - /1.5м/ - 5000 төг	4 нас /1.5м/ - 5000*10 =50,000	Жилд 1 удаа	Багануур дүүргийн БАГАНУУР-ОЙ мод үржүүлгийн газар
2	Нарс		Нарс нь хоосон үржил шимгүй хөрс шороо, тэр ч байтугай хад хясаан дээр ч ургаж чаддаг. Нарс мод хүний дархлааг нэмэгдүүлж, интерферон хэмээнх бодис ялгаруулдагаараа бусад модноос онугой ялгардаг.	10ш	100,000	100,000*10 =1,000,000	Жилд 1 удаа	
Нийт тоо, хэмжээ				20ш		1,050,000		

Хүснэгт 4. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд дараагийн 5 жилд тарих модны тооцоолол

№	Тарих модны төрөл	Тариалах газар	Ач холбогдол	Жилд тарих модны тоо, ширхэг	Үнэ 2025 оны байдлаар, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Авах боломжтой газар
1	Улиас	Нийслэлээс зааж өгсөн газарт	Улиас нь бургасны овогт хамаарна, фитонид хэмээх агаарыг цэвэршүүлэх бодисыг их агуулдаг тул хот сууринд тарьж ургуулахад тохиромжтой.	40ш	4 нас /1.5м/ - 5000*40=200,000	Жилд 1 удаа	Багануур дүүргийн БАГАНУУР-ОЙ мод үржүүлгийн газар
2	Нарс		Нарс нь хоосон үржил шимгүй хөрс шороо, тэр ч байтугай хад хясаан дээр ч ургаж чаддаг. Нарс мод хүний дархлааг нэмэгдүүлж, интерферон хэмээнх бодис ялгаруулдагаараа бусад модноос онугой ялгардаг.	10ш	130,000*10 =1,300,000	Жилд 1 удаа	
Нийт тоо, хэмжээ				50	1,500,000		

1.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Тухайн төслийн хувьд нөлөөллийн бүсэд суурьшлын бүс байхгүй байна.

1.4 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол төслийн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг авран хамгаалах ажлыг зохион байгуулсан болно.

1.5 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ажилчдын бие өвдөх, халдварт өвчин гарах	Ажилчдын эрүүл мэндийн үзлэг	Нийт ажилчид	120	100.0	Дотоод төсөв	Жилд 1 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 2022-11-11 нэмэлт
2	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр төслийн кемпийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах, угааны мэдрэгч, гал гарсан тохиолдолд ашиглах зориулалттай галын автомат гидрант, аврах шат, хаалга, тэдгээрийн байршлын тойм зураглал, яаралтай мэдээлэл дамжуулах цахилгаан холбоо зэргээр бүрэн тоноглох/ жил бүр шалгах	Нийт ажилчид	-		1300.0	Жилд 1 удаа	Галын аюулгүй байдлын тухай хууль 2015.12.04 нэмэлт шинэчилсэн найруулга
3	Үйлдвэрийн осол, гэмтэл, хордох	Ажилчдыг зориулалтын хувцас хэрэгсэл, хошуувч, малгайгаар хангах	Нийт ажилчид	120	300	Дотоод төсөв	Сар бүр	MNS 12.4.009-88, MNS 12.4.013- 84-ын дагуу
		Хүн хортой нөхцөлд ажилладаг ажилчдад хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох	Эрсдэлтэй ажлын байранд ажилладаг ажилчдад	30	2000	Дотоод төсөв	Сар бүр	Хөдөлмөрийн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
4	Халдваргүйжүүлэлт хяналт, бүртгэл	Ажлын байр, агуулах, ажлын орчинд ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийж хяналт тавих	Үйлдвэрийн бүх объект	м ²	300	Дотоод төсөв	Сар бүр	
	Нийт					1300.0		

1.6 Удирдлага зохион байгуулалт

Хүснэгт 6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Төслийн хүчин чадал энэхүү тайланд тусгагдсанаас өөр нэмэлт өөрчлөлт орох бүрд дахин байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай.	Тохиролцох	Жилдээ	ХАБЭА, Ерөнхий менежер	Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 7.4, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам (Засгийн газрын 374 тогтоолын 2-р хавсралт)-ын 4.13- заалт
2	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	Тохиролцох	Жилдээ	ХАБЭА, Гүйцэтгэх захирал	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг БОУАӨЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тайланг батлуулж байх	Үйл ажиллагааны зардал	Жил бүрийн 1 болон 11 сард	Ерөнхий менежер	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.12-р заалт, БОУАӨ-ын сайдын 2019 оны А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
4	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101 зүйлийн дагуу байгаль орчны аудитыг хийлгэх /2 жил тутамд/	Дотоод төсөв	10 сар	ХАБЭА, Ерөнхий менежер	Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн онцгойлон анхаарах зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх.
5	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх	Дотоод төсөв	5 сар	ХАБЭА, Ерөнхий инженер	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.4-т заасны дагуу гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам
6	Мэргэжлийн байгууллагаар Хөдөлмөрийн нөхцөлийн Үнэлгээ хийлгэх	Дотоод төсөв	6 сар	ХАБЭА, Ерөнхий инженер	Хөдөлмөрийн тухай хууль
7	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ	Дотоод төсөв	8 сар	ХАБЭА, Ерөнхий менежер	Хөдөлмөрийн тухай хууль

1.7 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлыг ангилан, ялгах зориулалтын цэгийг тохижуулах	Хог хаягдлын цэг	Иж бүрэн	1 удаа	3 550.0	3 550.0	6 сар	БОУАӨС-ын сайдын А/433 тогтоол Хог хаягдлын тухай хууль
2	Эзэмшил газрын ил задгай хаягдсан хог, хаягдлыг ангилан ялгаж цэвэрлэж байх	Төвийн ойр орчмын 100 метрт	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		Сар бүр		
3	Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах	Төслийн талбайд	Иж бүрэн	1 удаа	1000.0	1000.0	5 сар	
4	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Дахин ашиглагдах хог хаягдал	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		Сар бүр		
5	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хог хаягдлын цэгт	Тогтмол	Улиралд 1 удаа	50.0	200.0	Улирал бүр	
6	Шингэн хог хаягдлыг стандартад нийцүүлэх, УЦБ барьж аш иглалтад оруулах	Шингэн хог хаягдлын	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		жилдээ		
7	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх	Үйлдвэрийн ажилчдад	удаа	Үйл ажиллагааны зардал		жилдээ	Засгийн газрын 116 тогтоол	
8	Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх	Төслөөс үүсэх хог хаягдал	удаа	Үйл ажиллагааны зардал		6 сар		
9	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах	Хог хаягдлын нэгдсэн менежмент	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардал		жилдээ	Хог хаягдлын тухай хууль	
Нийт дүн						4750.0		

Хүснэгт 8. Хог хаягдлын ангилал, зэрэглэл

	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл	Код	Аюулын зэрэглэл	Жилд гарах хэмжээ	Дахин боловсруулах	Устгах	Хадгалах	Тээвэрлэгчид нийлүүлэх	
	Шингэн хог хаягдал	T 0305	-	-	Тийм	Үгүй	Юнилосс бага оврын бохир ус цэвэршүүлэх байгууламж	бага оврын цэвэршүүлэх байгууламжтай болох	
Сав баглаа боодол (ангиан ялгасан ахуйн сав баглаабоодлын хаягдал орно)	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол	15 01 09*	A	20ш /0.3-.0.5л /	Үгүй	Тийм	Химийн бодисны агуулахын тусдаахэсэг гаргаж хадгалдаг	“Элемент” ХХК- тай байгуулсан гэрээний дагуу шилжүүлжустгуулдаг. Тайланд гэрээний хуулбарыг хавсаргав	
	Фреоны даралтад сав Аммикийн хий даралтад сав		A	-				Битүү циклтэй тул даралтад савны хаягдал үүсдэггүй	
	Гал тогооны үлдэгдэл			2тн	Тийм	-	Хуванцар саванд хадгалах	гахайн фермерт ангилж өгдөг.	
	Дугуйн хаягдал	16 01 01		20ш	Тийм	Үгүй	Үйлдвэрийн хашаанд байрлах 40 тонны контейнерт хадгалах	“Инахас” ХХК-д нийлүүлэх	
	Ахуйн гаралтай хог хаягдал	T01 T0301	-	32.2 тн	Тийм	Үгүй	Зориулалтын тагтай саванд ангиан ялгаж хадгалах	дүүргийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу тээвэрлэх	
Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	Хортой бодисоор бохирдсон шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	15 02 01	A	50 кг		-	Тийм	Тусгай зориулалтын хуванцар хаягдлын саванд	Аюултай хог хаягдлыг устгах, зайлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан ажиллах
				5 кг					
Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тосны	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны бусад	13 02 05*	A	500 кг	Үгүй	Тийм	Зориулалтын тагтай саванд ангиан ялгаж		

хаягдал	тос						хадгалах	
	Шланк, хоолой	16 01 18*	А	50кг	-	Тийм	Тусгай зориулалтын хуванцар хаягдлын саванд	
Ашиглалтаас гарсан машин, механизм, тэдгээрийг задлах болон засварлах үйл ажиллагаанаас үүсэх хаягдал(13, 14, 16 06, 16 08-аас бусад)	Жийрэг резинүүд	16 01 18*	А	5кг	-	Тийм		
	Аккумулятор	16 06 01*	А	300кг	Тийм	Тийм		Аюултай хог хаягдлыг устгах, зайлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Үлэмж хүдэр” ХХК-тай гэрээ байгуулан ажиллах
Мах, загас болон бусад амьтны гаралтай хүнс бэлтгэх, боловсруулах үед үүсэх хаягдал	Амьтны эд эрхтний хаягдал	02 02 02	Хүснэгт 74, 75-д дэлгэрүүлж оруулаа			Тийм	Тусгай зориулалтын даацын шуудайнд хийж хөлдөөдөг	Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх
	Ашиглах болон боловсруулах боломжгүй хаягдал	02 02 03				Үгүй	Тусгай зориулалтын хуванцар хаягдлын саванд	дүүргийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу тээвэрлэх
	Хаягдал усны анхан шатны цэвэрлэгээнээс үүсэх лаг	02 02 04				Үгүй		дүүргийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу тээвэрлэх
	Угаалга, цэвэрлэгээнээс үүсэх лаг	02 02 01				Үгүй	Насосоор цуглуулан тусгай зориулалтын хуванцар хаягдлын саванд цуглуулж хөлдөөдөг	Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх

Тус мах боловсруулах үйлдвэрээс мах бэлтгэлээс арьс, шир, яс, эвэр туурай, сэвс, цус зэрэг дайвар эд эрхтэн гарах бөгөөд эдгээрээс арьс ширийг нь дотоодын иргэн, аж ахуй нэгжид нийлүүлдэг эвэр туурай, сэвс, яс, цус нь хаягдал болж гарах бөгөөд эдгээрийг Сонгинохайрхан дүүргийн ТҮК-тай байгуулсан гэрээний дагуу нэгдсэн хогийн цэгт хаядаг. 2026 онд тус үйлдвэр эдгээр дайвар хаягдлыг дахин боловсруулах технологи оруулж ирэхээр гэрээ хийсэн байна.

Үйлдвэр нь 8-10-р саруудад буюу жилд 120 хоног мал бэлтгэх үйл ажиллагаа явуулах бөгөөд энэ үед хоногт 2,000 бог, 400 бод мал бэлтгэнэ. Энэхүү үйл ажиллагаанаас дараах технологийн хог хаягдал гарахаар байна.

Хүснэгт 9. Технологийн хатуу хог хаягдлын тооцоо

Эх үүсвэр	Хог хаягдлын нэр төрөл	Хоногт	Жилд	Устгах үйл ажиллагаа
Мах бэлтгэлээс	Хонины арьс	2,000 ш	240,000 ш	Дотоодын иргэн, ААН-д нийлүүлдэг.
	Ямааны арьс			
	Үхрийн шир	400 ш	48,000 ш	
	Яс	235.2 тн	28,224 тн	Гэрээний дагуу нэгдсэн хогийн цэгт зайлуулдаг.
	Эвэр, туурай	2,400 ш	288,000 ш	Гэрээний дагуу нэгдсэн хогийн цэгт зайлуулдаг.
	Сэвс	50.4 кг	6,048 кг	Шүүрэнд шүүгээд шингэн нь хэсгийг бохирын трап руу, өтгөн хаягдлыг нь гэрээний дагуу нэгдсэн хогийн цэгт зайлуулдаг.
	Цус	50.4 л	6,048 л	Цусыг бохирын трап руу зайлуулдаг.
Дотоод хяналтын лабораториос	Химийн бодисын шилэн сав	Үйлдвэрийн дотоод хяналтын лабораторийн үйл ажиллагаанаас лабораторид ашиглагдаж буй химийн бодисуудыг эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй ААНБ-аас гэрээний үндсэн дээр БОАӨЯ-наас олгосон “Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл”-ийн дагуу худалдан авдаг. Худалдаалагч байгууллагын шилэн савтай нь хадгалж ашигладаг.		Гарах тохиолдолд “Элемент” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу шилжүүлж устгуулдаг. Тайланд гэрээний хуулбарыг хавсаргав.
Хөргүүрийн хэсгээс	Фреоны даралтад сав	Битүү циклтэй тул даралтад савны хаягдал үүсдэггүй.		
	Аммиакийн хий даралтад сав			

Технологийн шингэн хаягдал

Тус үйлдвэрийн үндсэн технологийн дамжлагат ус ашиглана. Дамжлага бүрээс шингэн хаягдал гарна. Шингэн хаягдлын хэмжээг Дэлхийн банк, Монгол улсын байгаль орчны яамаас боловсруулсан гарын авлагад усны нийт хэрэглээ (Үйлдвэрийн усны хэрэглээ)-ний 75% нь шингэн хаягдал болно гэсэн тооцооллын дагуу тооцвол 1 хоногт 1,963 м³, 1 жилд 235,468 м³ шингэн хаягдал гарна. Тус мах бэлтгэх үйлдвэр нь 8-10-р сард мал бэлтгэлийг хийдэг бөгөөд эдгээр саруудад технологийн шингэн хаягдал гарна

№	Үйлдвэр	Усны хэрэглээ, м ³		Шингэн хаягдал, м ³	
		Хоног	Жил	Хоног	Жил
1	Үхрийн арьс	2,064	247,680	1,507	180,806
2	Хонины арьс	624	74,880	456	54,662
	Нийт	2,688	322,560	1963	235,468

1.8 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Сайдын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/428 дугаар тушаалын хавсралт ХОГ ХАЯГДЛЫН УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ТОГТОЛЦОО, БҮРДЭЛ БОЛОН МЭДЭЭЛЭЛ ТӨВЛӨРҮҮЛЭХ ЖУРАМ ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Энэ журмын 2.3-д заасан ангиллын дагуу сум, дүүргийн Засаг дарга нь сум дүүргийн хог хаягдлын мэдээллийн санг, аймаг нийслэлийн Засаг дарга нь аймаг, нийслэлийн хог хаягдлын мэдээллийн санг, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын мэдээллийн санг бүрдүүлнэ.
- 6.2. Хог хаягдлын тухай хуулийн 11.3-д заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цахимаар болон цаасан хэлбэрээр энгийн хог хаягдлын мэдээ тайланг харьяалах сум дүүргийн Засаг дарга, аюултай хог хаягдлын мэдээ тайланг харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.
- 6.3. Хэрэв эрх бүхий этгээд хэд хэдэн аймаг, сум, дүүргийн нутаг дэвсгэр дамжин үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тухайн аймаг, сум, дүүрэг тус бүрээр тайлангаа гаргаж харьяа сум, аймаг, дүүрэгт хүргүүлнэ.
- 6.4. Зохих шатны Засаг дарга мэдээ тайланг бүрэн хүлээн авах, нэгтгэх ажлыг зохион байгуулж, холбогдох дээд шатны байгууллагад цахимаар болон цаасаар илгээнэ.
 - 6.4.1. Сум, дүүргийн Засаг дарга тухайн орон нутагт энгийн хог хаягдлын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас мэдээ тайланг бүрэн хүлээн авах ажлыг зохион байгуулж, жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад батлагдсан маягт, загварын дагуу цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.
 - 6.4.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутагт аюултай хог хаягдлын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас мэдээ тайланг бүрэн хүлээн авах ажлыг зохион байгуулж, жил бүрийн 12 дүгээр сарын 20-ны дотор Байгаль орчны асуудал эрхэлсэн захиргааны төв байгууллагад батлагдсан маягт, загварын дагуу цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

6.5. Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайлангаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан маягтын дагуу гарган мэдээллийн нэгдсэн санд оруулах ба эх тайланг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын архив 5 жил хадгална.

Тус төслийн хувьд хог хаягдлын менежментийн ангилах, хадгалах, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар устгуулах зэрэг дээр маш сайн анхаарч ажилладаг байна.

— ХОГ ХАЯГДАЛ БА ЗР —
ЗР-ийн зарчим гэж юу вэ?

REDUCE
Хог хаягдлыг бууруулах,
усны гамгүй хэрэглээг багасгах

REUSE
Нэг удаагийн бүтээгдэхүүн сонгохын оронд дахин ашиглагдах,
удаан хэрэглээтэй бүтээгдэхүүн сонгох

RECYCLE
Боломжтой бүх эд материалыг дахин боловсруулах,
дахин боловсруулсан бүтээгдэхүүн худалдан авч хэрэглэх

3R

Эх үүсвэр: Greenpreneurs Society

<p>ЦААС PAPER</p> <p>✓ Давтрийн цаас болон цагаан цаас ✓ Бүх төрлийн цаасан хайрцаг ① Нороогүй, хоол хүнсний бохирдолгүй байх</p> <p>Уутны өнгө: ЦЭНХЭР</p>	<p>ШИЛ, ЛААЗ GLASS & CANS</p> <p>✓ Арх, лива, дорсон ногооны шил ✓ Бүх төрлийн шилэн сав ✓ Лоозолсон бүтээгдэхүүний сав ✓ Ундааны лааз ✓ Тугалган сав ✓ Шил, савны төмөр таг ① Савыг сулласан байх</p> <p>Уутны өнгө: УЛБАР ШАР</p>	<p>ХУВАНЦАР PLASTIC</p> <p>✓ Ундаа ус, хоолны хуванцар сав ✓ Галгар уут ✓ Гоо сайхан, ахуйн хэрэглээний бүх төрлийн хуванцар ① Савыг сулласан байх</p> <p>Уутны өнгө: НОГООН</p>	<p>БУСАД ХОГ NON RECYCLABLE</p> <p>✓ Дахин боловсруулагдахгүй байгаа бусад хог</p> <p>Уутны өнгө: ХАР</p>
--	--	---	--

1.1.7 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Нийслэл, хорооны ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	-
БОУАӨЯ, НБОГ		Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	-

ОРЧНЫ ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Мах-Импекс” ХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг нь “Нью тек мандала” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн нэгжийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас эрх бүхий байгууллагуудыг татан оролцуулна.

Хүснэгт 10. Төслийн талбайн мониторингийн хяналт шинжилгээний цэгүүд

№	Байршил	Цэгийн дугаар	Солбилцол	
			Уртраг	Өргөрөг
Агаарын хяналт шинжилгээ хийх цэгийн байршил				
1	Төслийн талбайд	Агаар 1	107°18'23.55"E	47°46'6.79"N
Хөрсний хяналт шинжилгээ хийх цэгийн байршил				
2	Төслийн талбайд	Хөрс 1	107°18'25.03"E	47°46'6.60"N
3		Хөрс 2	107°18'9.65"E	47°46'4.13"N
Ургамлын хяналт шинжилгээ хийх цэгийн байршил				
1	Ногоон байгууламж	Ургамал 1	107°18'25.54"E	47°46'6.35"N
2		Ургамал 2	107°18'27.27"E	47°46'10.39"N
Усны хяналт шинжилгээ хийх цэгийн байршил				
1	Төвийн шугам	Ус 1	107°18'24.10"E	47°46'9.58"N

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	1 жилд зардал (урьдчилсан мян.төг)	Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	<p>Агаарын чанар:</p> <p>O₂, SO₂, CO, NH₃ Агаарын тоос PM_{2.5}, PM₁₀ Дэгдэмхий бодиснуудыг тодорхойлох үйлдвэр болон агуулхын цогцолборын орчмын дуу чимээний шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх</p>	<p>Төслийн талбайд -Сорилын лаб -Химийн бодис хадгалах тусгай өрөө -Үйлдвэрийн шат дамжлага бүр дээр цэг сонгох</p>	<p>Тоосны хяналт: Төслийн талбай заасан цэгт жилд 2 удаа /хавар, намар, зун, өвөл/ Ажлын ид үеэр</p> <p>Агаарын найрлага: жилд 2 удаа</p>	400.0	<p>MNS 4585-2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга</p>
2	<p>Усны хяналт шинжилгээ: - Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO₃), Ca, Mg, Na, K, SO₄, NO₂, NO₃, NH₄, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол) -Нянгийн шинжилгээ -Нийт болон чөлөөт цианид -Бохир усны шинжилгээ</p>	<p>Төслийн талбайд дараах байршлуудад сонгох -Гал тогооны төвийн цэвэр усны хэсэг -Хаягдал ус нийлүүлэх хэсэг</p>	Жилд 2 удаа	500.0	<p>MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2010 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт</p>
3	<p>Хөрсний төлөв байдал, бохирдол: Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO₃, P₂O₅, K₂O), хөрсний механик</p>	<p>Төслийн талбайд дараах байршлуудад сонгох -Үйлдвэрийн авто бааз засварын төвийн зогсоол -Үйлдвэрийн түүхий эд хүлээн авах цэг</p>	Жилд 2 удаа 5, 9сард	500.0	<p>MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга,</p>

	бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, Хүнд металлын шинжилгээ (K, Ca, Ti, Cr, Mn, Fe, Co, Cu, Zn, As, Se, Sr, Pb, Hg S, Cl тодорхойлох Нийт болон чөлөөт цианид	-Түүхий эдийн хуримтлалын цэг -Төв замаас үйлдвэрийн хашааны хаалга хүрэх үед цэг сонгох			MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
4	Ургамлан нөмрөг: Ургамлан нөмрөгийн маршрутын судалгааны бичиглэлд заасан үзүүлэлтүүд, ургамлуудын мониторинг хийх	Төслийн талбайн хашаанаас эргэн тойрон 1 км радиуст	Төслийн хэрэгжилтийн туршид жилд нэг удаа (9 сард)	Дотоод төсөв	Ургамлан нөмрөгийн маршрутын судалгааны бичиглэл
Нийт				1400.0	

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2026 оны нэгдсэн дүн

№	Хэрэгжүүлэх ажил	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	2500
2	Орчны цэцэрлэгжүүлэлт, нөхөн сэргээлтийн ажлын зардал	2550
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлын зардал	1300
4	Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	4750
5	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Үйл ажилгааны дотоод зардалаар тусган хэрэгжүүлнэ
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1400
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	Үйл ажилгааны дотоод зардалаар тусган хэрэгжүүлнэ
НИЙТ ЗАРДАЛ		12500